



Батлав. ШУТИС.МехТС-ийн захирал



Н.Пүрэвдорж

"МОНГОЛ ИНЖЕНЕР - 2024"

CAD/CAE/CAM, ТЕХНИКИЙН МЕХАНИКИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

Зорилго:

Инженерийн зохион бүтээх үйл ажиллагааг хөгжүүлэх, инженерийн төсөл, тооцоонд механикийн онолын болон зураг төслийн тооцооны загварчлалыг мэргэжлийн түвшинд өргөн хүрээнд хэрэглэх ур чадвартай шилдэг инженер, оюутныг шалгаруулах, инженер судлаач, багш нарын мэдлэг, ур чадварыг туршлагаас харилцан солилцох, хуваалцах зорилготой.

Хамрах хүрээ:

Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Их, дээд сургууль, Технологийн коллеж, Коосен зэрэг сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгагдсан CAD/CAE/CAM болон механикийн суурь хичээл болох *Онолын механик, Материалын эсэргүүцэл, Механизмын дизайн, Машины эд анги, Хэрэглээний механик* зэрэг хичээлүүдийг судалдаг гадаад, дотоодын сургуулиудын оюутнууд оролцох боломжтой.

CAD/CAE/CAM, Техникийн механикийн Улсын олимпиадын хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээ:

- ✓ Их, дээд сургуулиудын оюутнуудын дунд зохион байгуулагдах CAD/CAE/CAM-ийн олимпиад (Бат бэхийн тооцоолол, эд ангийн 3D байгуулалт, угсаргаа болон ажлын зураг гаргах);
- ✓ Их, дээд сургуулиудын оюутнуудын дунд зохион байгуулагдах Техникийн механикийн хичээлийн бодлогын уралдаан (эгэл болон бодлогын хэсэг);
- ✓ Багийн тэмцээн (Өгөгдсөн даалгаврыг тодорхой багаж, төхөөрөмжийн тусламжтайгаар гүйцэтгэх, туршилт хийх, хэмжилтийн үр дүн, бодолтыг харьцуулах г.м).

Оролцогчдод тавигдах шаардлага:

- ✓ Ганцаарчилсан төрлөөр оролцогч нь их, дээд сургуульд суралцагч бакалавр оюутан байна;
- ✓ Их, дээд сургуулиас оролцож буй баг нь тухайн сургууль дээр зохион байгуулагдсан өмнөх шатны шалгаруулалтад оролцож шалгарсан байна;
- ✓ Сургууль төлөөлөх баг нь 3-5 бакалавр оюутан, 1 удирдагч багшийн бүрэлдэхүүнтэй байна;
- ✓ Мэдүүлгийн маягыг www.mongol-engineer.mn цахим хуудаснаас татаж авна.

Хугацаа:

- ✓ Оролцох багийн мэдүүлэг болон бүртгэлийн хураамж төлсөн баримтын хамтаар **2024.04.15**-ны дотор olympiadmt@must.edu.mn цахим хаягаар хүлээн авна;
- ✓ Олимпиадын журмыг www.mongol-engineer.mn цахим хуудсанд байрлуулна;
- ✓ Олимпиадын үйл ажиллагаа **2024.04.27, 28**-ны өдөр (Бямба, Ням гариг) Улаанбаатар хотод ШУТИС-ийн Төв номын санд зохион байгуулагдана.

Бүртгэл, хураамж:

Үйл ажиллагааны санхүүжилтэд зориулж оролцох байгууллага, сургууль, хувь хүмүүс:

- ✓ Техникийн механикийн болон CAD/CAE/CAM улсын олимпиадад оролцох Их, дээд сургуулийн баг 500 000 төгрөг;
- ✓ CAD/CAE/CAM-ийн улсын олимпиадад хувийн үзүүлэлтээр оролцох оюутан 50 000 төгрөг; Техникийн механикийн улсын олимпиадад хувийн үзүүлэлтээр оролцогч 20 000 төгрөгийн тус хураамжтай. Бүртгэлийн тоо хязгаартай.
- ✓ Хураамжийг Голомт банкны 811-510-3646 тоот дансанд тушаана.
Хүлээн авагчийн нэр: ШУТИС Механик, тээврийн сургууль

Гүйлгээний утга: ТМ, CAD/CAE/CAM-ын олимпиад. Байгууллагын нэр Оюутны овог, нэр, кирилл үсгээр, гар утасны дугаар.

Шагнал, урамшуулал: Оролцсон бүх хүмүүст батламж олгоно.

Техникийн механикийн улсын олимпиад	Оюутан хувийн дүнгээр
1-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.5 сая.төг
2-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.4 сая.төг
3-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.3 сая.төг

Техникийн механикийн улсын олимпиад	Оюутны багийн тэмцээн
1-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.8 сая.төг
2-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.6 сая.төг
3-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.4 сая.төг
Удирдагч багш	0.2 сая.төг

CAD/CAE/CAM улсын олимпиад	Оюутан хувийн дүнгээр
1-р байр - өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал	1.5 сая.төг
2-р байр - өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал	1.0 сая.төг
3-р байр - өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал	0.75 сая.төг

Ерөнхий зохион байгуулагч:

Боловсрол, шинжлэх ухааны яам
ШУТИС-ийн Инновац, технологи дамжуулалтын төв
ШУТИС.Механик, тээврийн сургууль

Хамтран зохион байгуулагч:

ХААИС-ийн Инженер технологийн сургууль
ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургууль
Төмөр замын дээд сургууль
Бусад Инженер технологийн их, дээд сургуулиуд

Ерөнхий ивээн тэтгэгч байгууллага:

Металл боловсруулалт, инженерчлэлийн холбоо

Техникийн механикийн улсын олимпиадтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг:

ШУТИС.МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн эрхлэгч,

док (Ph.D), дэд профессор, Ш.Цоож, 99274776

ШУТИС.МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн

ахлах багш, док (Ph.D), Т.Мөнхбат, 99075768

ШУТИС.МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн

ахлах багш, Т.Бямбадорж, 88336599

CAD/CAE/CAM-ийн улсын олимпиадтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг:

ШУТИС.МехТС-ийн Машин үйлдвэрлэлийн салбарын эрхлэгч, док (Ph.D), Г.Оюунбат, 99782458

Металл боловсруулалт, инженерчлэлийн холбооны нарийн бичгийн дарга, Г.Энхтуул, 89017727

ШУТИС.МехТС-ийн Машин үйлдвэрлэлийн салбарын багш, З.Баатар, 91999188

Цахим хуудас: mongol-engineer.mn

Facebook хаяг: [Mongol Engineer](https://www.facebook.com/MongolEngineer)

Майл хаяг: olympiadmt@must.edu.mn, mongolengineer@must.edu.mn

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, ШУТИС.МехТС, 7-403, 7-401

ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

2024.03.26